



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/21

Сүхбаатар

Тусгай зөвшөөрөл шинээр олгох,
сунгах тухай

Монгол Улсын аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 12.1, 15.12.4, 16.2.2, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19.2 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хушаат, Цагааннуур, Түшиг, Ерөө, Сант, Алтанбулаг, Орхонтуул, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Баянгол, Хүдэр сум, Мандал сумын Түнхэл, Хэрх тосгон, Ерөө сумын Бугант тосгон, Шаамар сумын Дулаанхан тосгон, Орхонтуул сумын Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвүүдийн, Сайхан сумын сум дундын эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар, Сүхбаатар сумын “Өөжиг дент”, Мандал сумын “Инээмсэглэл” шүдний эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.

2.Мандал сумын “Хишиг ДБ”, Бугант тосгоны “Өлгий Ерөө” эмийн сан, Сүхбаатар сумын “Монос” эм ханчан нийлүүлэх байгууллагад тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаатайгаар тус тус олгосугай.

3.Тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж , мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од-/д , Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ

